



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А/15

Чойр

Цэргийн бүртгэл явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, 17.1.9, Цэргийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйл, Батлан хамгаалахын сайдын 2017 оны А/331 дүгээр тушаалаар батлагдсан “Цэргийн бүртгэл явуулах журам”-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цэргийн бүртгэлийн ажлыг удирдан зохион байгуулж, хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:	Д.Содном (Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)
Орлогч дарга:	Ц.Нацагдорж (Цэргийн штабын дарга, хурандаа)
Гишүүд:	П.Наранмандах (Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын дарга) Б.Отгонжаргал (Шивээговь сумын Засаг даргын Тамгын газрын дарга) Ц.Лхагвадонид (Баянтал сумын Засаг даргын Тамгын газрын дарга) Ш.Батсүх (Ахлах прокурор)
Нарийн бичгийн дарга:	Н.Оюунбат (Цэргийн штабын тоо бүртгэлийн ахлах офицер, хошууч)

2.Цэргийн бүртгэлийг явуулах ажлын хэсгийн ажил үүргийн хуваарийг 1 дүгээр, комиссын ажиллах хуваарийг 2 дугаар, цэргийн тоо бүртгэл явуулахад шаардагдах төсвийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Цэргийн тоо бүртгэлийг зохион байгуулахад шаардагдах 1,696,000 (Нэг сая зургаан зуун ерэн зургаан мянга) төгрөгийг цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн орлогоос зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Содном)-д зөвшөөрсүгэй.

2024/01/08

4.Цэргийн бүртгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс 01 дүгээр сарын 31-ний өдрүүдэд зохион байгуулж, дүнг 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсгийн дарга (Д.Содном)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТСУУРЬ

Аймгийн Засаг даргын 2024 оны...⁰²
дүгээр сарын ...⁰² -ны өдрийн ...^{А/05}
дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

ЦЭРГИЙН БҮРТГЭЛИЙГ ЯВУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН
АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ

1. Дарга:

- Цэргийн бүртгэл явуулах комиссын ажлыг удирдаж, зөрчил дутагдлыг арилгуулах
- Захирамжийн заалт нэг бүрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах
- Цэргийн бүртгэлийн үр дүнг аймгийн Засаг даргад танилцуулах

2. Орлогч дарга: Цэргийн штабын дарга

- Цэргийн бүртгэлийн явцад хяналт тавих
- Цэргийн бүртгэл явуулж буй албан тушаалтнуудад үүргээ биелүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх
- Цэргийн бүртгэлийн материалыг шалган, хүлээн авахад хяналт тавих
- Дайчилгааны нөөцийг тооцож дүн шинжилгээ хийх

3. Нарийн бичгийн дарга: Тоо бүртгэлийн ахлах офицер

- Цэргийн бүртгэлийн ажлыг зохион байгуулах, үр дүнг холбогдох албан тушаалтнуудад танилцуулах
- Цэргийн бүртгэлийн материалыг батлагдсан хуваарийн дагуу сумдаас шалган хүлээж авах, нэгтгэх
- Мэдээ судалгааг тогтоосон хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэх
- Цэргийн бүртгэлээс хоцорсон цэргийн үүрэгтнүүдэд хуулийн дагуу хариуцлага тооцох
- Байгууллага, аж ахуйн нэгж, сум багуудад хяналт шалгалт хийх ажлыг гардан гүйцэтгэх

4. Сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нар:

- Багийн ажлын цаг ашиглалтыг шалгах
- Багуудын ажилд хяналт тавьж үнэлэлт дүгнэлт өгөх, хариуцлага тооцох
- Ухуулга сурталчилгааны ажлыг зохион байгуулах
- Ажлын явцыг Цэргийн штабт тогтоосон цагт илтгэх
- Цэргийн бүртгэлийн мэдээ тайланг сумын хэмжээнд нэгтгэн гаргаж, тогтоосон хугацаанд хүргүүлэх.

Ажлын хэсэгт ДААЛГАХ нь:

3.1. Цэргийн бүртгэлийн ажлыг сум, багуудын хүн амын тоо бүртгэлтэй нягт уялдуулан зохион байгуулж, гишүүдийн ажил үүргийн хуваарийг тогтоон, бүртгэл явуулахад шаардлагатай автомашин, ажлын байр, хүн хүчийг гаргаж ажиллуулах;

3.2. Цэргийн бүртгэлийн ажлыг хуулийн дагуу Засаг захиргааны үндсэн нэгж сум, багт төвлөрүүлэн зохион байгуулж, эрхлэн гүйцэтгэх албан тушаалтнуудад хууль тогтоомж, тоо бүртгэлийг зохион байгуулах журам, шаардлагатай гарын авлага, материалаар ханган, тоо бүртгэлийн ажилд хяналт тавьж ажиллах;

3.3. Цэргийн бүртгэлийг иргэдэд хүндрэл учруулахгүйгээр зохион байгуулж, стандартын дагуу маягтуудыг боловсруулан тодотгож, нууцын горимыг чанд сахин ирүүлэх;

3.4. Цэргийн бүртгэлийн үеэр ард иргэд, цэргийн үүрэгтнүүдэд цэргийн албаны тухай хууль, бусад холбогдох эрх зүйн баримт бичгүүдийг сурталчилгааны материал, орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр өргөн сурталчлах, тайлбарлан таниулах ажлыг шуурхай зохион байгуулах;

3.5. Цэргийн бүртгэлийг явуулсан тухай тайлан, дүн мэдээг тогтоосон хугацаанд нь Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабт хүргүүлэх;

4. Сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, багийн Засаг дарга нарт ДААЛГАХ нь:

4.1. Цэргийн бүртгэлийг хүн амын тоо бүртгэлтэй нягт уялдуулан явуулж, байнгын оршин суугч оюутнуудыг оршин сууж буй хаягаар нь, түр оршин суугч оюутан сурагчдыг сурч байгаа сургуулиар нь бүртгэн цахим үнэмлэхийн бүртгэлийн маягт, өрхийн дэлгэрэнгүй бүртгэлийн дэвтрийн хөтлөлттэй нь тулган давхар хяналт тавьж ажиллах;

4.2. Цэргийн үүрэгтэн, бэлтгэл офицеруудын цэргийн бүртгэлийн ажлыг багийн Засаг дарга нар гардан хийж маягт №4, маягт №12-ыг бүрэн, үнэн зөв хөтлөх;

4.3. Цэргийн албыг сайн дураар гэрээгээр хаах болон, цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах журмыг иргэдэд сурталчлах, цэргийн гэрээт алба хаах болон цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийн судалгааг гаргах;

4.4. Сум, багуудад тоо бүртгэл явуулах журмыг хэрэгжүүлэн ажиллах, цэргийн бүртгэл явуулсан тухай дүн, тайлан мэдээнүүдийг сумаар нэгтгэн батлагдсан хуваарийн дагуу тушаах;

4.5. Цэргийн бүртгэлээс завсардагчдыг бүртгэлд хамруулах ажилд Цагдаагийн байгууллага, иргэний бүртгэл мэдээллийн ажилтнууд болон сонгуульт ажилтнуудыг татан оролцуулах;

4.6. Цэргийн тоо бүртгэлийг хангалтгүй зохион байгуулсан, тайлан мэдээг хугацаанд нь чанартай гаргаж ирүүлээгүй тохиолдолд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг ажлын хэсгийн дарга, сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарт үүрэг болгосугай.

Аймгийн Засаг даргын 2024 оны 01...
дүгээр сарын ...08...-ны өдрийн ...*A. J. G.*...
дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

ЦЭРГИЙН БҮРТГЭЛ ЯВУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН
АЖИЛЛАХ ХУВААРЬ



Д/д	Хийх ажил	Сар өдөр
1	2	3
1	Байгууллага, аж ахуйн нэгжийн цэргийн үүрэгтнүүдийг хуваарийн дагуу бүртгэх	01 дүгээр сарын 08-аас 01 дүгээр сарын 31
2	Сум багуудад шалган туслах ажил явуулах	01 дүгээр сарын 08-аас 01 дүгээр сарын 31
3	Сүмбэр, Баянтал, Шивээговь сум тоо бүртгэлийн мэдээг цэргийн штабт өгөх	02 дугаар сарын 03-ны өдөр
4	Аймгийн нэгдсэн мэдээ гаргах	02 дугаар сарын 04-07-ны өдөр
5	БХЯ, ЗХЖШ-т цэргийн бүртгэлийн мэдээ өгөх	02 дугаар сарын 08-09-ны өдөр

Аймгийн Засаг даргын 2024 оны 01...
дугаар сарын 08...-ны өдрийн 1/05.
дугаар захирамжийн 3 дугаар хавсралт

АЙМГИЙН ХЭМЖЭЭНД 2024 ОНЫ ЦЭРГИЙН БҮРТГЭЛ ЗОХИОН
БАЙГУУЛАХ ТӨСВИЙН ЗАДАРГАА

д/д	Зориулалт	Зардлын тооцоо	Төлөвлсөн /мян, төг/	Тайлбар
1	Холбооны зардал	Утасны нэгж /14 хүн х 20000/	280000	10 багийн Засаг дарга, Сумдын ЗДТГ-ын дарга
2	Тээврийн зардал	100 км-т 15л LPG зарах автомашин 1 нэгж буюу 120 литр х1800=216000	216 000	10 багаар автомашинтай тойрох, УБ хот ЗХЖШ, БХЯ-нд мэдээг хүргэх
3	Бичиг хэргийн зардал	Бичгийн цаас 10Х20000=110000	200 000	
4	Цэргийн үүрэгтний үнэмлэх	500Х2000	1 000 000	
	Нийт зардал		1696000	